



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2022 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 04

Мандалговь

**Т.Саранчимэгийг аймгийн Мэргэжлийн хяналтын
газрын Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын
хэлтсийн даргын албан тушаалд
нэр дэвшүүлэх тухай**


Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2021 оны 7 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Төрийн захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Төмөрийн Саранчимэг 87.0 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Т.Саранчимэгийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг Салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ш.ТӨРБАТ





**Мэргэжлийн хяналтын газрын Төрийн захиргаа, эрсдэлийн
удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд
нэр дэвшүүлсэн Т.Саранчимэгийн тухай дүгнэлт**

1. Т.Саранчимэг нь 1988 онд Дундговь аймгийн Эрдэнэдалай суманд төрсөн. 33 настай, эмэгтэй
2. Боловсрол: 2006-2010 онд Хөдөө аж ахуйн их сургуулийг газрын кадастрын инженер мэргэжлээр бакалаврын зэрэгтэй суралцаж төгссөн.
3. Туршлага: 2011-2012 онд Говь-Угтаал сумын ЗДТГ-ын байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн, газрын даамал, 2012 оноос Мэргэжлийн хяналтын газарт Байгаль орчны хяналтын улсын байцаагч, хэлтсийн дарга, улсын ахлах байцаагчаар ажиллаж байна.
4. Т.Саранчимэгийн төрийн албаны туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан Мэргэжлийн хяналтын газрын Захиргаа, эрсдэлийн удирдлагын хэлтсийн даргын албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛ